

Ү.ОТГОНБАЯР

Монголын математикийн олимпиадыг зохион байгуулах удирдамж

2026 оны 04 сарын 22 өдөр

1 Ерөнхий үндэслэл

- 1.1 Монголын математикийн олимпиад (цаашид “Олимпиад” гэх)-ыг зохион байгуулахад Боловсролын Ерөнхий Газрын даргын 2023 оны 12 сарын 04 өдрийн А/420 тоот тушаалаар баталсан *Улсын олимпиад зохион байгуулах журмыг* баримтална.
- 1.2 Энэхүү удирдамжаар олимпиадыг зохион байгуулах ангилал, шатлал, олимпиадад оролцох эрх олгох, байр эзлүүлэх аргачлал, бодлого сонгох, засах, бодолт хамгаалах болон бусад зохион байгуулалттай холбоотой асуудлуудыг зохицуулна.
- 1.3 Олимпиад зохион байгуулах зорилго:
 - 1.3.1 Математикт дур сонирхолтой, авъяаслаг сурагчдыг нээх, дэмжих, хөгжүүлэх, цаашид олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцуулах
 - 1.3.2 Математикийн багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хамтын ажиллагааг дэмжих, туршлага солилцох боломжийг нэмэгдүүлэх
 - 1.3.3 Математикийн шинжлэх ухааныг олон нийтэд таниулан сурталчлах, дэлгэрүүлэх
- 1.4 Олимпиадын үйл ажиллагаа нь санхүүгийн чадамж, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэг, хүйсийн чиг баримжаа, бие махбодын онцлог зэрэгтэй холбоотой аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байна. Түүнчлэн сэтгэл санаа, бие махбодын аливаа хүчирхийлэл болон улс төр, санхүү эдийн засаг, шашны нөлөөллийг үл зөвшөөрнө. Олимпиадын үйл ажиллагаанд оролцогчид бие биедээ харилцан хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандах үүрэгтэй.

2 Зохион байгуулалтын багууд

Математикийн олимпиадын дэд хороо: Улсын олимпиад зохион байгуулах журмын 3.3 заалтын дагуу энэхүү удирдамжийг Математикийн олимпиадын дэд хороо батална.

Зохион байгуулагч: Олимпиадын зохион байгуулалтын асуудлыг хариуцаж оролцогчдыг олимпиадад тав тухтай оролцох боломжоор ханган хяналтын багийг удирдаж ажиллана. Мөн тусгайлан өөрөөр заагаагүй бол олимпиад зохион байгуулах санхүүжилтыг хариуцна.

Эрдмийн баг: Хороог төлөөлж олимпиадын эрдмийн үйл ажиллагааг хариуцаж бодлогын багийг удирдаж ажиллана. Олимпиадад оролцох эрхийг эрдмийн баг олгоно.

Бодлогын баг: Бодлого зохиох, бусдын дэвшүүлсэн бодлогыг хүлээж авах, хянах, сонгохтой холбоотой асуудлууд болон бодлогын нууцлалыг хариуцна. Бодлого засах аргачлалыг боловсруулж эрдмийн багаар батлуулна.

Засалтын баг: Батлагдсан бодлого засах аргачлалын дагуу бодолт засах ажил болон засалт хамгаалах ажлыг хариуцна. Засалтын багийг эрдмийн баг эсвэл зохион байгуулагч томилох ба томилогч олимпиадын дүн болон шагналуудыг батална.

Хяналтын баг: Эрдмийн баг ба зохион байгуулагчийн зааврын дагуу танхимын бодолтыг дүрмийн дагуу шударга зохион байгуулж оролцогчдын бодолтуудыг системд оруулах болон засалтын багт хүлээлгэж өгөх ажлыг хариуцна.

3 Ангилал

3.1 Олимпиадад төрийн өмчийн болон төрийн өмчийн бус ерөнхий боловсролын сургуулийн (цаашид сургууль гэх) сурагчид болон үндсэн багш, захирал, сургалтын менежер (цаашид багш гэх) нар оролцож болох ба оролцогчид

C, D, E, F, S, T

гэсэн зургаан ангилалд уралдана.

3.2 C ангилалд 5, 6 дугаар ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 6 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.3 D ангилалд 7, 8 дугаар ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 8 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.4 E ангилалд 9, 10 дугаар ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 10 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.5 F ангилалд 11, 12 дугаар ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилал бүх сурагчдад нээлттэй.

3.6 S ангилалд бага ангийн багш нар оролцож болно.

3.7 T ангилалд багш нар оролцож болно.

4 Шатлал

4.1 Олимпиадыг

I даваа, II давааны I шат, II давааны II шат, III даваа

гэсэн дөрвөн шатлалтай зохион байгуулна.

4.2 I давааг сургуулийн олимпиад гэж нэрлэнэ.

4.3 II давааны I шатыг Улаанбаатар хотод дүүргийн, хөдөө орон нутагт аймгийн олимпиад гэж нэрлэнэ. Багануур, Багахангай, Налайх дүүргүүд энэ шатлалыг хамтран зохион байгуулна.

4.4 II давааны II шатыг Улаанбаатар хотод нийслэлийн, хөдөө орон нутагт бүсийн олимпиад гэж нэрлэнэ. Аймгуудыг дараах байдлаар бүсэд хуваана.


Бүс	Аймаг
Баруун	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
Говь	Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь
Төв	Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл
Зүүн	Дорноговь, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий

4.5 III давааг улсын олимпиад гэж нэрлэнэ.

4.6 Шатлал бүрд дараах ангиллууд зохион байгуулагдана.

Шатлал	Ангилал					
I даваа	C	D	E	F		
II давааны I шат	C	D	E	F	S	T
II давааны II шат		D	E	F	S	T
III даваа			E	F		T

4.7 Оролцогчид шатлал бүрээс дараагийн шатлалын тухайн ангилалдаа оролцох эрхээ авах ба шатлал ахихад ангилал солих боломжгүй. Эрх авсан оролцогч олимпиадад оролцох боломжгүй болсон тохиолдолд нөхөж эрх олгохгүй. Мөн II давааны I шатнаас III даваанд оролцох эрх авах боломжтой ба энэ тохиолдолд II давааны II шатанд заавал оролцох шаардлагагүй.



4.8 Тухайн шатлалд 0 оноо авсан оролцогч дараагийн шатлалд оролцох боломжгүй.

4.9 Өөрөөр заагаагүй тохиолдолд багийн зохион байгуулалтыг дараах байдлаар хийнэ.

Шатлал	Бодлогын баг	Засалтын баг	Хяналтын баг
I даваа	хороо	систем	сургууль
II даваа I шат	хороо	аймаг/дүүрэг	аймаг/дүүрэг
II даваа II шат	хороо	бүс/нийслэл	бүс/нийслэл
III даваа	хороо	хороо	зохион байгуулагч

5 I даваа

5.1 I даваа буюу сургуулийн олимпиадыг C, D, E, F ангиллуудаар сурагчдын дунд зохион байгуулна. Энэ шатлал ангиллын шаардлага хангасан бүх сурагчид нээлттэй.

5.2 Сургуулийн олимпиад зохион байгуулагдахаас 4 долоо хоногийн өмнө олимпиад зохион байгуулах ажлын хэсгийг сургуулийн захирал томилох ба үйл ажиллагаатай холбоотой төсвийг тухайн жилийн төсөвт суулган санхүүжүүлнэ.

5.3 Олимпиадад оролцох багш сурагчдын бүртгэлийн асуудлыг ажлын хэсэг хариуцна.

5.4 Олимпиадыг нөхөх тест хэлбэрээр нэг өдөр зохион байгуулна.

5.5 Бодлогын багийг хороо томилно.

5.6 Засалтыг mmo.mn системээр хийнэ.

5.7 Ядаж 1 оноо авсан сурагчдыг ангилал бүрд нийлбэр оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, дараах байдлаар II давааны I шатанд оролцох эрх олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно. Босго оноог багасгах эсвэл нэг сургуулиас оролцох сурагчийн тоог ихэсгэх замаар зохион байгуулагч оролцогчийн тоог нэмэх боломжтой.

Дүүргийн эрх, сургуулиас: Ангилал бүрд сургууль бүрийн эхний 3 сурагч дүүргийн олимпиадад оролцох эрх авна.

Дүүргийн эрх, жагсаалтаар: Сургуулиудад дүүргийн олимпиадад сүүлийн жилүүдэд үзүүлсэн амжилтад үндэслэн нэмэлт эрх олгоно. Нэмэлт эрхийг ангилал бүрд тухайн сургуулийн сурагчдаас сүүлийн гурван жилд дүүргийн олимпиадад эхний 50 байрт шалгарсан сурагчдын дундаж тоог дээш нь бүхэлчилж тооцно.

Аймгийн эрх, сургуулиас: Ангилал бүрд сургууль бүрийн эхний 2 сурагч аймгийн олимпиадад оролцох эрх авна.

Аймгийн эрх, жагсаалтаар: Сургуулиудад аймгийн олимпиадад сүүлийн жилүүдэд үзүүлсэн амжилтад үндэслэн нэмэлт эрх олгоно. Нэмэлт эрхийг ангилал бүрд тухайн сургуулийн сурагчдаас сүүлийн гурван жилд аймгийн олимпиадад эхний **20** байрт шалгарсан сурагчдын дундаж тоог дээш нь бүхэлчилж тооцно.

5.8 Шагналын асуудлыг ажлын хэсэг шийдвэрлэнэ.

6 II давааны I шат

6.1 II давааны I шат буюу *аймаг/дүүргийн* олимпиадыг C, D, E, F, S, T ангиллуудаар зохион байгуулна.

6.2 Бодлогын багийг хороо томилно. Бусад зохион байгуулалтыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлэн зохион байгуулна.

6.3 C, D, S ангилалд 1 өдөр $\times$ 4 бодлого/өдөр, E, F, T ангилалд 2 өдөр $\times$ 3 бодлого/өдөр тавигдана.

6.4 Энэ шатлалд багш нар болон I даваанаас эрх авсан сурагчид оролцоно.

Тухайн дүүрэг эсвэл аймагт I даваа зохион байгуулагдаагүй тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага оролцох эрхийг шийдвэрлэнэ.

	Жагсаалтаар	Сургуулиас
Аймаг	20	2
Дүүрэг	50	3

Босго оноог багасгах эсвэл нэг сургуулиас оролцох сурагчийн тоог ихэсгэх замаар зохион байгуулагч оролцогчийн тоог нэмэх боломжтой.

6.5 Ядаж нэг 1 оноо авсан оролцогчдыг ангилал бүрд нийлбэр оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, дараах байдлаар дараагийн шатлалд оролцох эрхийг олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно.

Хотын эрх, дүүргээс: Сурагчдын ангилал бүрд дүүргүүдийн эхний **20** байрт шалгарсан сурагчид, багш нарын ангилал бүрд дүүргүүдийн эхний **10** байрт шалгарсан багш нар нийслэлийн олимпиадад оролцох эрх авна.

Хотын эрх, жагсаалтаар: Дүүргүүдэд нийслэлийн олимпиадад сүүлийн жилүүдэд үзүүлсэн амжилтад үндэслэн нэмэлт эрх олгоно. Нэмэлт эрхийг сурагчдын ангилал бүрд тухайн дүүргийн сурагчдаас сүүлийн гурван жилд нийслэлийн олимпиадад эхний **30** байрт шалгарсан сурагчдын дундаж тоог дээш нь бүхэлчилж тооцно.

Багш нарын ангилал тус бүрд нийт **10** оролцогчийн эрхийг мөн дээрх аргачлалаар хуваарилан дүүргүүдэд олгоно.

Бүсийн эрх: D, E, F ангилалд аймгуудын эхний **10** байрт шалгарсан сурагчид болон S, T ангилалд эхний **5** байрт шалгарсан багш нар бүсийн олимпиадад оролцох эрх авна.

Улсын эрх: E, F, T ангилалд аймаг, дүүрэг бүрээс тус бүр эхний **2** байрт шалгарсан нийт **6** багш, сурагч улсын олимпиадад оролцох эрх авна. Оноо тэнцсэн оролцогчдыг II давааны II шатны оноогоор жагсаан эрх олгоно.

6.6 Шагналын асуудлыг зохион байгуулагч шийдвэрлэнэ.

7 II давааны II шат

- 7.1 II давааны II шат буюу *бүс/нийслэлийн* олимпиадыг D, E, F, S, T ангиллуудаар зохион байгуулна.
- 7.2 Бүсийн олимпиадыг тухайн бүсийн аль нэг аймаг зохион байгуулна.
- 7.3 Бүсийн олимпиадыг зохион байгуулагч аймгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага олимпиад зохион байгуулах ажлын хэсэг ба засалтын багийг томилох ба олимпиадын үйл ажиллагааг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Бүсийн олимпиадад оролцох зардлыг оролцогч аймгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 7.4 Хотын олимпиадыг зохион байгуулагчийг болон засалтын багийг нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага томилох ба үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 7.5 Энэ шатлалд II давааны I шатнаас эрх авсан багш, сурагчид оролцоно.

Хаана		D	E	F	S	T	Нийт
Баруун бүс	5	10	10	10	5	5	200
Говийн бүс	4	10	10	10	5	5	160
Төвийн бүс	7	10	10	10	5	5	280
Зүүн бүс	5	10	10	10	5	5	200
Нийслэл	7	20	20	20	10	10	670
	1	30	30	30	10	10	
Нийт		350	350	350	180	180	1510

Зохион байгуулагч аймаг нь босго оноог багасгах замаар бүсийн олимпиадад оролцох оролцогчийн тоог нэмэгдүүлэх боломжтой. Мөн зохион байгуулагч аймаг 10 хүртэл хүнтэй нэг баг нэмэлтээр оруулах эрхтэй.

- 7.6 E, F ангилалд бүсийн олимпиадад оролцох эрх авсан оролцогч энэ шатлалд нийслэлийн олимпиадад оролцож болно. Энэ тохиолдолд нийслэлийн олимпиад зохион байгуулах хороонд урьдчилан заасан хугацаанаас өмнө бүртгүүлж зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Зохион байгуулагчийн зүгээс нэг аймгаас оролцох оролцогчийн тоонд зааг тавьж болно.
- 7.7 Бүсийн олимпиад зохион байгуулагдаагүй тохиолдолд тухайн бүсээс улсад оролцох эрхийг нийслэл рүү шилжүүлнэ.
- 7.8 II давааны I шатнаас III даваанд оролцох эрх аваагүй оролцогчдыг ангилал тус бүрд нийт оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, III даваанд оролцох нэмэлт эрхийг дараах байдлаар олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно.
- Улсын эрх, бүсээс:** Бүсийн E, F ангилал тус бүрд дээрх жагсаалтын эхний **2** байрт жагссан сурагч, T ангиллын эхний **1** байрт жагссан багш III даваанд оролцох эрх авна.
- Улсын эрх, нийслэлээс:** Нийслэлийн E, F ангилал тус бүрд дээрх жагсаалтын эхний **20** байрт жагссан сурагч, T ангилалд эхний **6** байрт жагссан багш III даваанд оролцох эрх авна.
- 7.9 Шагналын асуудлыг зохион байгуулагч шийдвэрлэнэ.

8 III даваа

- 8.1 III даваа буюу *улсын* олимпиадыг E, F, T ангиллуудаар зохион байгуулна.
- 8.2 Улсын олимпиад зохион байгуулах хүсэлтийг хороо хүлээн авч батална.

8.3 Зохион байгуулах ажлын хэсгийг зохион байгуулагч болон хороо хамтран томилно.

8.4 Энэ шатлалд II давааны I шат, II давааны II шатнаас эрх авсан багш, сурагчид оролцоно.

Эрх	Хаана		Е	Ү	Т	Нийт
II даваа I шат	Аймаг	21	2	2	2	126
	Дүүрэг	7	2	2	2	42
II даваа II шат	Бүс	4	2	2	1	20
	Нийслэл	1	20	20	6	46
	Нийт		84	84	66	234

Улсын эрх, зохион байгуулагчаас: Зохион байгуулагчийн зүгээс хүсэлт гаргавал 6 хүртэлх хүнтэй нэг баг нэмэлтээр оролцуулж болох ба энэ багт нэмэлт шаардлага тавихгүй.

8.5 Е, Ү ангилалд медалийг дараах байдлаар олгоно.

8.5.1 Алтан медалийн болзлыг 1-2 сурагч хангахаар хамгийн цөөн алтан медаль өгнө.

8.5.2 Алт, мөнгөн медалийн болзлыг 5-8 сурагч хангахаар хамгийн цөөн мөнгөн медаль өгнө.

8.5.3 Алт, мөнгө, хүрэл медалийн болзлыг 14-18 сурагч хангахаар хамгийн цөөн хүрэл медаль өгнө.

8.5.4 Дээрх нөхцөлүүдийг бүгдийг хангахаар медаль өгөх боломжгүй бол медалийн хуваарилалтыг хороо шийднэ.

8.6 Т ангилалд медалийг дараах байдлаар олгоно.

8.6.1 Алтан медалийн болзлыг 1-2 багш хангахаар хамгийн цөөн алтан медаль өгнө.

8.6.2 Алт, мөнгөн медалийн болзлыг 3-4 багш хангахаар хамгийн цөөн мөнгөн медаль өгнө.

8.6.3 Алт, мөнгө, хүрэл медалийн болзлыг 6-8 багш хангахаар хамгийн цөөн хүрэл медаль өгнө.

8.6.4 Дээрх нөхцөлүүдийг бүгдийг хангахаар медаль өгөх боломжгүй бол медалийн хуваарилалтыг хороо шийднэ.

8.7 Зохион байгуулагчийн зүгээс нэмэлт шагналыг санаачлах боломжтой.

9 Олимпиадад оролцох үед баримтлах дүрэм

Ерөнхий шаардлага

9.1 Бодолтын цаг эхлэхээс 20 минутын өмнө гэхэд бодолтын танхимд суудлаа эзэлсэн байна. Бодлого задарснаас хойш оруулахгүй.

9.2 Бодолтод зөвхөн үзэг, бал, шугам, гортиг, баллуур гэх мэт бичих болон зурах хэрэгсэл ашиглаж болно.

9.3 Компьютер, гар утас, таблет, тооны машин, ухаалаг цаг болон бусад цахим төхөөрөмж болон холбооны хэрэгсэл ашиглахыг хориглох ба бодолтын танхим руу авч орохгүй байна.

9.4 Овог, нэр, ID, бодлогын дугаар зэрэг мэдээллийг бодолтын цаг дуусахаас өмнө бодолтын цаасан дээр бичсэн байх шаардлагатай ба мэдээлэл дутуу бол засалт хийгдэхгүй байх эрсдэлтэй болохыг анхаарна уу.

9.5 Геометрийн бодлогын зураг зураагүй бол бодолтоос 1 оноо хасна.

- 9.6 Үнэр, чимээ багатай хөнгөн идэх, уух зүйлс бодолтын танхимд авч орж болох ба бодолтын үеэр хэрэглэж болно.
- 9.7 Бие засахдаа хянагчид мэдэгдэн нэг нэгээрээ гарна. Эхний 1 цаг болон сүүлийн 30 минутад бодолтын танхимаас гарахгүй.
- 9.8 Бодолт эхэлснээс хойш 30 минутын хугацаанд бодлогын өгүүлбэртэй холбоотой асуултыг бичгээр асууж болно.
- 9.9 Бодолтын цаасны зөвхөн нүүрэн талд бичих ба ард талд бичсэн бичвэрт засалт хийхгүй.
- 9.10 Бодолтын цаасан дээр нэгээс олон бодлогын бодолтыг хольж бичихгүй.
- 9.11 Бодолтын цаасан дээр хуудасны дугаар, бодолтоо дуусаад тухайн бодлогын бодолтын нийт хуудасны тоог бичнэ.
- 9.12 Бодолт дууссан бол бодолтын цаасаа хянагчид тоолон хүлээлгэж өгөх ба хяналтын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулна.

Ёс зүйн шаардлага

- 9.13 Бодолтын цаг эхэллээ гэж зарлах хүртэл бодлого харахгүй бөгөөд бодолтын цаг дууслаа гэж зарласны дараа бодолтын цаасанд нэмэлт өөрчлөлт оруулахгүй.
- 9.14 Бодлогоо бие даан бодох ба бусдаас аливаа хэлбэрийн тусламж авахыг хориглоно.
- 9.15 Бодолт болон хамгаалалтын үеэр хянагч, зохион байгуулалч болон хорооны гишүүдтэй хүндэтгэлтэй харьцаж, тэдний зүй ёсны шаардлагыг биелүүлнэ.
- 9.16 Дээрх заалтуудыг зөрчсөнтэй холбоотой гомдлыг Математикийн олимпиадын дэд хороогоор авч хэлэлцэх ба тодорхой хугацаагаар олимпиадын үйл ажиллагаанд оролцох эрхийг хасах хүртэл арга хэмжээ авч болно. Дэд хорооны шийдвэр эцсийн байна. Ноцтой тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандана.

10 Бодолт хамгаалах

- 10.1 Зохион байгуулагчийн зүгээс өөрөөр заагаагүй бол бодолт хамгаалалтыг дараах байдлаар хоёр үе шаттай зохион байгуулна.
- 10.2 Бодолтын зургийг mmo систем рүү оруулна. Бодолт оруулаагүй тохиолдолд хамгаалалтад орох боломжгүй.
- 10.3 Өөрийнхөө урьдчилсан оноог mmo системээс харна.
- 10.4 Бодолт хамгаалах хүсэлтийг mmo системээр өгөх ба ямар үндэслэлээр дүгнэх аргачлалын аль хэсгээс хэдэн оноо авах хүсэлтэй байгаагаа тодорхой бичнэ.
- 10.5 Засалтын баг хүсэлтийг авч хэлэлцээд mmo системээр хариу өгнө.
- 10.6 Дээрх хариуг хүлээн зөвшөөрөхгүй бол багш нь танхимаар хамгаалалт хийнэ.
- 10.7 Бодлого хариуцсан засалтын багтай ойлголцолд хүрээгүй тохиолдолд хорооноос томилсон өргөтгөсөн баг асуудлыг авч хэлэлцэх ба энэ багийн шийдвэр эцсийн байна.
- 10.8 Шаардлагатай тохиолдолд засалтын баг оролцогчийг дуудан бодолтын талаар тайлбар авч болно.

11 Бодлого дэвшүүлэх

- 11.1 Олимпиадад бодлого дэвшүүлэх эрх ашиг сонирхлын зөрчилгүй бүх хүнд нээлттэй.
- 11.2 Олимпиадад зөвхөн өөрийн зохиосон шинэ бодлогыг дэвшүүлэх ба дэвшүүлсэн бодлогын нууцлалыг чандлан хадгална. Тухайлбал, тухайн бодлого болон түүнтэй төстэй бодлогыг өөр олимпиад уралдаанд дэвшүүлэхгүй.
- 11.3 Бодлого дэвшүүлэхдээ дараах мэдээллийг бодлогын багийн ахлагчид олимпиад болохоос нэг сарын өмнө өгнө.
 - 11.3.1 Овог, нэр
 - 11.3.2 Харьяаллын албан байгууллага, сургууль болон албан тушаал
 - 11.3.3 Ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэл (үүнд хичээл заадаг эсвэл ойрын хамаатан оролцогчийн талаарх мэдээлэл орно)
 - 11.3.4 Бодлого
 - 11.3.5 Бодолт
 - 11.3.6 Бодлогын тухай мэдээлэл (хүндрэл, санааны эх сурвалж гэх мэт)
- 11.4 Бодлого сонголтыг бодлогын баг хариуцна. Тухайлбал, бодлогыг дэвшүүлэх эсэх болон аль шатлалын аль ангилалд эсвэл сонгон шалгаруулах сорил, олон улсын олимпиадууд дэвшүүлэхийг бодлогын баг шийднэ.